

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2020 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

**“Монгол Улсын Их Хурал 30 жил”.
оин хүндэт медаль бий
болгох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

- 1.Байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 30 жилийн ойд зориулж “Монгол Улсын Их Хурал 30 жил” оин хүндэт медаль бий болгосугай.
- 2.“Монгол Улсын Их Хурал 30 жил” оин хүндэт медалийн тодорхойлолтыг 1 дүгээр хавсралтаар, оин хүндэт медаль олгох журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
- 3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

Монгол Улсын Их Хурлын 2020 оны
... дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**“МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ 30 ЖИЛ” ОЙН ХҮНДЭТ
МЕДАЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

Нэг.Медалийн хэлбэр дүрс, бэлгэдэл

1.1.“Монгол Улсын Их Хурал 30 жил” ойн хүндэт медаль нь зүүлт, тэмдэг гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

1.2.Медалийн нүүрэн талын төв хэсэгт төрийн алтан соёмбыг хүндэтгэлийн бадам цэцэг суурин дээр товойлгон дурсэлж түүний доод талд “Монгол Улсын Их Хурал” гэсэн крилл үсгэн бичигтэй байна.

1.3.Медалийн нүүрэн талын төв хэсгийн бадам цэцэг суурийн голд 30 гэсэн тоо байх бөгөөд алтан соёмбын хоёр талд “Монгол Улсын Их Хурал 30 жил” гэсэн монгол бичигтэй байна.

1.4.Медалийн нүүрэн талын төв хэсгийн их биеийн гадна хүрээ нь үүрд мөнх, төгсгөлгүй үргэлжлэн дэлгэрэх түмэн насан хээгээр хөвөөлсөн.

1.5.Медалийн ар тал нь үүрд мөнх, төгсгөлгүй үргэлжлэн дэлгэрэх түмэн насан хээгээр хөвөөлсөн байх бөгөөд хүрээний голд Төрийн ордны дурслэлтэй, түүний доод талд “Байнгын ажиллагаатай парламент 1990-2020” гэсэн крилл үсгэн бичигтэй, дээд талд нь дахин давтагдахгүй серийн дугаартай байна.

1.6.Медалийн дээд талын зүүлт нь Монгол Улсын төрийн далбаа бүхий тууттай байна.

Хоёр.Медалийн техникийн үзүүлэлт

2.1.Медалийн их бие нь 40 мм-ийн диаметртэй байна. Нүүрэн талд 18.4 x 9.1 мм-ийн харьцаа бүхий алтан соёмбыг товойлгон дурсэлнэ.

2.2.Медалийн ар талд нь Төрийн ордны дурслэлийг 9.5 x 27.6 мм-ийн харьцаатай товойлгон өгсөн байна.

2.3.Медаль нь алтан шаргал өнгөтэй, үндсэн материал нь цайрын хайлш байна.

2.4.Зүүлтийн тууз нь 28 x 22.1 харьцаатай, Төрийн далбааны өнгө бүхий давуун материалтай байх бөгөөд алтан шаргал өнгөтэй, цайрын хайлш хүрээтэй байна.

2.5.“Монгол Улсын Их Хурал 30 жил” гэсэн монгол бичиг нь хөх өнгөтэй байна.

2.6.“Монгол Улсын Их Хурал” гэсэн крилл үсгэн бичиг нь хөх өнгөтэй байна.

2.7.Бад цэцгэн суурь нь шар хүрээтэй, цагаан өнгөтэй байна.

2.8.Бад цэцгэн суурийн 30 гэсэн тоо нь хөх өнгөтэй байна.

----ooOoo----

Монгол Улсын Их Хурлын 2020 оны
... дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**“МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ 30 ЖИЛ” ОЙН ХҮНДЭТ
МЕДАЛЬ ОЛГОХ ЖУРАМ**

1.“Монгол Улсын Их Хурал 30 жил” ойн хүндэт медалийг Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гарган шагнаж, үнэмлэх олгоно.

2.“Монгол Улсын Их Хурал 30 жил” ойн хүндэт медалиар Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурал, Улсын Их Хурлын гишүүд, Улсын Бага Хурал, Улсын Их Хурлын Тамгын газрын албан хаагчид болон байнгын ажиллагаатай парламентыг хөгжүүлэх, хууль тогтоох засаглалыг бэхжүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсан төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, дипломат ажилтан, эрдэмтэн судлаач, сэтгүүлчид, төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, олон улсын байгууллагын төлөөллийг шагнана.

3.“Монгол Улсын Их Хурал 30 жил” ойн хүндэт медалиар шагнуулах хүмүүсийн нэрийн жагсаалтыг ажилласан жил, ажлын амжилтыг харгалзан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар баталсан “Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”-д заасны дагуу эрх бүхий албан тушаалтан Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

4.“Монгол Улсын Их Хурал 30 жил” ойн хүндэт медалийг байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 30 жилийн ойг тэмдэглэх үйл ажиллагааны хүрээнд тухайн жилд багтаан хүмүүст олгоно.

5.“Монгол Улсын Их Хурал 30 жил” ойн хүндэт медалиар нэхэн шагнахгүй.

6.“Монгол Улсын Их Хурал 30 жил” ойн хүндэт медалийг үнэмлэхийн хамт Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, дэд дарга, гишүүн, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга болон эрх бүхий албан тушаалтан шагнагдсан хүмүүст гардуулна.

----ооОоо----